



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.03.14 № 74  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ  
СҮЛЖЭЭ ОНӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.БҮҮВЭЙБААТАР ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 119/ШШ2023/0001 дугаартай Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр 199.9 сая төгрөгийн нөхөн ногдуулалтын актын үлдэгдэл төлбөр болох 186.4 сая төгрөгийг Булган аймгийн Татварын хэлтсийн нэхэмжлэхээр шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 06 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 26,256.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 26,715.7 сая төгрөгөөр, 459.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,805.2 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 28,004.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 28,041.8 сая төгрөгийн зардал гарган, 37.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдлыг төлөвлөснөөс 421.6 сая төгрөгөөр бууруулж ажиллажээ.

Тайлант онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 3,175,162.3 м<sup>3</sup> ус хүлээн авч, 2,137,427.6 м<sup>3</sup> ус буюу 67.32 хувийг борлуулж, 32.68 хувь буюу 1,037,734.8 м<sup>3</sup> усыг орлого болоогүй усны өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2023 оны гүйцэлгэлийн төлөвлөгөөнд 15 зорилт, 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлийг дээд шатны захирагч 98.05 хувьтай гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэгэн төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ